



2024 ОН III УЛИРЛЫН ТАЙЛАН

MSE:MLG
www.mlholding.mn



ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол улсын Тээврийн салбарын орлогын өсөлт

^ **+24%**

Монложистикс Групп Борлуулалтын орлогын өсөлт

^ **+50%**

Монложистикс Групп Тээвэрлэсэн ачааны өсөлт

^ **+10%**

Монложистикс Групп Импорт ачаа тээврийн өсөлт

^ **+27%**

Монложистикс Групп Экспортын ачаа тээврийн өсөлт

^ **+10%**

Монложистикс Групп Транзит ачаа тээврийн өсөлт

^ **+9%**



КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 10 охин компани, 210 орчим ажилтан, 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол улсын тээврийн салбарын тэргүүлэгч байгууллага болсон байна.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлсээр байна.

Монложистикс Холдинг ХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч Группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, бизнес хөгжил, Ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

Эрхэм зорилго

Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд

Алсын хараа

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

Үнэт зүйлс

Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтэл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.

Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.

Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээр багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ





Монложистикс Транзит
ХХК байгуулагдав.

2019 ОН



Порфолио өргөжилт хийж,
3 охин компаниа байгуулав.

2021 ОН



Монложистикс Холдинг
ХХК Олон нийтэд
нээлтэй компани
болов.

2023 ОН



Төв азийн зам ХХК-ийн
51%-ийг өөртөө нэгтгэлээ.

2024 ОН

2018 ОН

Оюу толгой компанийн
албан ёсны тээврийн
компаниар шалгарав.



2020 ОН

Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.



2022 ОН

Түүхий эдийн экспортын
тээврийг эхлүүлж,
Каус Аустралис ХХК-ийг
байгуулав.




2023 ОН

Do good HUB ТББ-ыг байгуулав.




ГРУППИЙН БҮТЭЦ



*2024.01.01 -ний өдрөөс “Төв Азийн Зам” ХХК-г нэгтгээнд тооцно

**ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ БРЭНД**



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монложистикс Тракинг ХХК

2024 оны 8-р сараас эхлэн транзит тээврийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто замаар БНХАУ-ын Такашкен боомтоос ОХУ-ын Ташанта боомтоор дамжуулан, ОХУ-ын Москва хот руу тогтмол транзит тээвэр зохион байгуулж эхэллээ.



Монложистикс Тракинг ХХК болон **Монложистикс Ворлдвайд ХХК** болон хамтран БНХАУ-ын Эрээн хотоос Монгол улсын Эрдэнэт хотын чиглэлд өргөн, өндөр, хэтрүү овортой ачааг / FLSmidth-н/ цуваагаар амжилттай зохион байгуулж тээвэрлэлээ.



Монложистикс Ворлдвайд ХХК

Hero entertainment ХХК-ийн Монгол Хаан жүжгийн тайз болон туслах хэрэглэлийг Монгол улсаас Сингапур улс руу агаараар экспортын тээвэр хийж гүйцэтгэлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



1. FUTURE CEO 2

Монложистикс Групп нь хүний нөөцийн бодлогын хүрээнд “Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл” үнэт зүйлсээ баримтлан, оюутан залуусын ирээдүйн хөгжилд оюунлаг хөрөнгө оруулалт хийхээр “Future Ceo 2” тэтгэлгийг 2 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

Тэтгэлгийн зорилго: Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэ цэн бүтээх, ирээдүйн манлайлагчдыг төрүүлэхэд бодит дэмжлэг болж, оюутан залуусын академик амжилтыг карьер амжилт болгох дээр дэмжиж ажиллахад оршино.


Уг тэтгэлгийг гадаад хэлтэй, олон улсын харилцааны мэргэжлээр 3,4-р курст суралцаж буй оюутнууд руу хандаж зарласан бөгөөд сургалтын 100% тэтгэлэг олгохоос гадна, 3-р курсээсээ эхлэн Монложистикс Группэд цалинтай ажиллах боломжийг олгож буй тэтгэлэг юм.

Түүнчлэн “FUTURE CEO 2” тэтгэлгийн эзэд болж буй 4 оюутнуудын хувьд Гүйцэтгэх захирлын ментор хөтөлбөр, ерөнхий ур чадварын сургалт, цалинтай ажлын байр гээд тус бүр нийт 80 саяын төгрөгийн тэтгэлгийг хүртэж байгаагаараа онцлогтой.

2. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ЗОРИУЛСАН ВЭБСАЙТ АШИГЛАЛТАД ОРЛОО

“Монложистикс Холдинг” ХК нь нээлттэй компанийн хүрээнд хувьцаа эзэмшигчид болон хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчдод мэдээллээ илүү нээлттэй, ил тод хүргэж, тэдгээртэй хэрхэн зөв харилцаатай байх тал дээр онцгой анхааран ажиллаж байна.

Үүний хүрээнд бид хөрөнгө оруулагчдад зориулсан вэбсайтыг ашиглалтад орууллаа. Хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчид Монложистикс Группийн санхүүгийн тайлан болон бусад мэдээллийг цаг алдалгүй доорх вэбсайтаас авах боломжийг бүрдүүлж өгсөн.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



3. ODOO ERP VERSION 17 ХУВИЛБАРЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ

Монложистикс Группийн хэмжээнд дижитал шилжилт хийх урт хугацааны зорилтот стратегийн хүрээнд байгууллагын үндсэн болон дэмжих үйл ажиллагааг автоматжуулах зорилгын хүрээнд Монголд анх удаа Odoo ERP V.17 хувилбарыг ахиулан гар утасны аппликейшнтэй болгон нэвтрүүлээ.

Мөн И-Коммерс үйлчилгээний Sheerah платформыг бид тасралтгүй сайжруулж, хөгжүүлсээр байна. 2024 онд Группийн хэмжээнд Data Warehouse төслийг эхлүүлсэн бөгөөд төсөл төгсгөлийн шатандаа амжилттай ороод байна.



4. OGSM2025 БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨГ АМЖИЛТТАЙ ХИЙЖ ДУУСГАЛАА

Монложистикс Групп жил бүрийн 8-р сараас ирэх оны бизнес төлөвлөлтийн ажлыг эхлүүлдэг ба Группийн “2025 оны бизнес төсөв төлөвлөгөөг” 8,9-р сард амжилттай боловсруулж дууслаа.

Бид бизнес төлөвлөгөөний олон улсын OGSM моделийг үйл ажиллагаандаа ашигладаг ба Группийн хэмжээнд нийт 11 компани дээр нэгтгэн хэрэгжүүлж байна. Толгой компанийн зүгээс “Өсөлт, Тогтвортой хөгжил” гэсэн 2 үндсэн зорилгыг охин компаниуддаа чиглэл болгон өгч, бизнесийн стратегийг тус бүр төлөвлөн ажиллаж байна.




Үйл ажиллагааны тайлан

- > Тээврийн салбарын нийт орлого
- > Монложистикс Группийн орлого
- > Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- > Монложистикс Группийн ачааны хэмжээ

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО III УЛИРАЛД 50.3% НЭМЭГДЭЖ ₮226.3 ТЭРБУМД ХҮРЛЭЭ.


МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО / ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР /



2024 оны 3-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.7% өссөн байна.


“Эх сурвалж: ҮСХ ийн мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.”

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО / ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2024 оны 3-р улирлын байдлаар Монложистикс Группийн орлого 226.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 50.3% өссөн байна.

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



2024 оны 3-р улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн эргэлтийн хэмжээ 88.5 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 20% өссөн байна.



МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



Монложистикс группийн ачаа эргэлт 864 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 10% өссөн үзүүлэлттэй байна.


ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ОЛОН УЛС ДАХЬ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@mlholding.mn

www.mlholding.mn